



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 1/243

Улаанбаатар хот

Г Үер, усны аюул, осол гэмтэл, халдварт  
өвчнөөс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх  
хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгалийн аюулт үзэгдлийн үед иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай газруудад мэргэжлийн байгууллагаар халдвартгүйжүүлэлт хийлгүүлэх, үр дүнд хяналт тавьж, болзошгүй халдварт өвчин тархалтаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл хүргэх ажлыг эрчимжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2. Халдварт өвчин тандалт, шуурхай хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

3. Осол, гэмтлийн тандалт, хариу арга хэмжээ, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахыг Гэмтэл, согог судлалын үндэсний төв /Э.Галбадрах/-д үүрэг болгосугай.

4. Гадаад, дотоод орчинд халдвартгүйжүүлэлт хийх талаар эрүүл мэндийн болон мэргэжлийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/-д үүрэг болгосугай.

5. Эрсдэлийн мэдээлэл харилцааг эрчимжүүлж, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулан зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд өгч ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /С.Өнөрсайхан/-д даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар/Д.Баярболд/, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар /С.Сүнчин/-т тус тус даалгасугай.

САЙД С.ЧИНЗОРИГ



141224102